



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2020.10.16 № 1а/4384
танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан таны тавьсан асуулгад дараах хариуг хүргүүлж байна.

НҮБ-ын "Тогтвортой хөгжлийн зорилт-2030"-д Хүчирхийллийн бүх хэлбэр болон хүчирхийллийн шалтгаантай нас баралтын түвшинг үлэмж хэмжээгээр бууруулах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, хүний наймаа, тамлан зовоох зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох" тухай заасан байдаг.

ДЭМБ-ын баримт бичигт "Жендэрийн уламжлалт үзэл хандлага, зан үйлээс үйдэлтэй хүчирхийлэл нь хувь хүн, гэр бүл, нийгмийн хөгжил, эдийн засагт ихээхэн хор уршиг учруулж буй нь дэлхийн хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг юм. Үүнд зөвхөн эрүүл мэндийн бус бусад салбарын оролцоог хангасан богино ба урт хугацааны урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх цогц үйлчилгээг хөгжүүлэх нь улс орон бүрийн төрийн бодлогын түвшинд авч үзэх ёстой асуудал" хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг билээ.

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл нь гол төлөв эмэгтэйчүүд охидын эсрэг үйлдэгдэж байгаа ч гол хохирогчид нь хүүхдүүд болж байна. Эрүүл мэндийн салбар хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдийг хүчирхийлэлийн дарамтад өртсөнийг эрт шатанд нь илрүүлж, гэмтэл бэртэл авахаас урьдчилан сэргийлэхийн тулд аюулгүй хамгаалагдсан орчинд, бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн багийн цогц үйлчилгээг цаг алдалгүй, чанартай хүргэх зорилго тавин ажиллаж байна.

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгч болон хүүхдийг хэвийн байдалдаа эргэн ороход дэмжин туслахад нийгмийн, халамжийн, эрүүл мэндийн, сэтгэл зүйн, хууль эрх зүйн салбар дундын оролцоог зангидсан зохион байгуулалт бүхий үр дүнтэй цогц үйлчилгээг "Нэг цэгийн үйлчилгээний төв"-өөр үзүүлдэг.

Таны ирүүлсэн албан бичгийн дагуу дараах тоо баримтыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

1. 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төвөөр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 810 хүн үйлчлүүлсэнээс насанд хүрсэн 717, хүүхэд 93 эмнэлгийн тусламж үйлчилгээ болон бусад шаардлагатай үйлчилгээг цогцоор нь авсан байна.

144208892